

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	2
1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	2
1.4. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	3
1.5. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ.....	4
1.5.1. ЦАХИЛГААН ХАНГАМЖ	4
1.5.2. УСАН ХАНГАМЖ	4
1.5. ТӨСЛИЙН БАЙРШИЛ.....	4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ.....	5
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	7
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ...8	
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
АРВАН ХОЁР. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДАЛ	24

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Гаалийн хяналтын талбай


Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Баялаг хатанбулаг хөгжил” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 0611008298
Регистрийн дугаар: 3323358

Хаяг: Дорноговь, Хатанбулаг, 5-р баг, Аман-Ус, эргэл, 15-7 тоот.
Утас 1: 88862555

1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


“Баялаг хатанбулаг хөгжил” ХХК нь 2021 онд байгуулагдсан ба Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 3-р багийн нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн, гаалийн хяналтын талбайн зориулалт бүхий 5.0 га талбайд үйл ажиллагаа явуулж байна.

Ачилт буулгалтын талбайн бүтэц: Авто зам, нүүрс буулгах талбай, хяналтын байр, авто пүү, хашаа-салхины хаалт, авто зогсоол, авто засвар, үйлчилгээний хэсэг, ажилчдын байр, оффис, гал тогоо



Зураг 1. Талбайн ерөнхий төлөвлөгөөний зураг

1.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ



Зураг 2. Технологийн процесс

Нүүрсийг Тавантолгой, “Айл баян” ХХК болон “Сор говь” ХХК-ийн нүүрсний ордуудаас задгай машинаар тээвэрлэн авчирч нүүрс буулгах талбайд буулган овоолго үүсгэн хадгалж, гаалийн үзлэгээр оруулан машинд ачин Ханги боомт руу тээвэрлэнэ.

Хүчин чадал: жилд 2,000.0 тонн хүртэл нүүрс экспортолно.

Нүүрч ачиж буулгах талбайд

- Хяналтын байр
- Автомашины орох, гарах талын пүү
- Нүүрс агуулах талбай (10000 тонн нүүрс хадгалах багтаамж бүхий 20000м²)
- Хучлагын талбай 1000м²
- Хашаа салхины хаалт

Нүүрч ачиж, буулгах талбайн гадна

- Авто зогсоол
- Авто засвар, үйлчилгээний хэсэг
- Ажилчдын байр, оффис, гал тогоо

1.4. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ



Зураг 3. Төслийн талбай дахь барилга байгууламжууд

1.5. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.5.1. Цахилгаан хангамж

Цахилгаан дамжуулах агаарын хос шугамыг шинээр татаж Зүүнбаяны 35/10 Кв-ын дэд станцад тус тус холбогдоно. Өртөөний трансформаторын багтаамж 200Ква-аас их тохиолдолд ХТП дэд станц бүхий байгууламжтай.



Зураг 4. Цахилгаан үүсвэр

1.5.2. Усан хангамж


Төслийн технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй, зөвхөн ажилчдын унд ахуйд ус ашиглах бөгөөд усны хэрэглээг зөөврөөр хангаж байна.

1.5. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Талбай нь засаг захиргааны хуваарилалтаар Дорноговь аймгийн төв Хатанбулаг сумын 3-р багийн нутаг дэвсгэрт харьяалагдах ба Улаанбаатар хотоос 700км, Сайншанд сумаас 300км, Хатанбулаг сумаас 120 км, Тавантолгойгоос 400 орчим км, Ханги мандал хилийн боомтийн ойролцоо байрлана.

Хүснэгт 1. Талбайн эргэлтийн цэг

№	Өргөрөг			Уртлаг		
1	42	41	33.4	109	58	16.97
2	42	41	38.15	109	58	23.48
3	42	41	32.62	109	58	30.9
4	42	41	27.87	109	58	24.39



Зураг 5. Гаалийн хяналтын талбайн байршлын зураг

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Төслийн талбайн нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их мужийн дэд муж болох Дорнод говийн мужийн Дорнод говийн тойрогт, байгалийн бүс бүслүүрээр цөлийн бүсэд хамаарагдана. Газрын гадаргын хувьд ерөнхийдөө уул нурууд байхгүй, ухаа гүвээт талын байрлалтай. Талбайн гадаргуугийн өндөр нь 682-805м өндрийн түвшинд хэлбэлзэнэ.

Уур амьсгал: Эх газрын уур амьсгалтай, хоногийн агаарын температур огцом өөрчлөлттэй. Жилийн дундаж температур $+4^{\circ}\text{C}$. Уур амьсгалын хувьд халуун хүйтний улирал болон өдөр шөнийн цагт хамгийн их зөрүүтэй ажиглагддаг. Зун нь дулаан урт үргэлжлэх ба өвлийн хүйтэн үе нь богино XII-I сар (-15°C - -21°C) хүртэл үргэлжилнэ. Харин халуун сар нь VII-VIII сар ($+20^{\circ}$ - $+30^{\circ}\text{C}$) дээд температур $+39^{\circ}\text{C}$ хүйтэн нь -39°C хүрдэг байна.

Геологийн тогтоц: Районы геологийн тогтцын хувьд Мезо-Кайнозойн настай тунамал ба хувирмал хурдас чулуулгаас бүрдэнэ. Мезо-Кайнозой нь цэрдийн үеийн тунамал баг бүрдүүлсэн байх бөгөөд энэ районд янз бүрийн ширхэглэлтэй элсэн чулуу, элс хайргархаг сланц, нягт шавар, конгломерат ба тэдгээрийн хувирмал хэсэг шавранцар ба шавар ихэвчлэн тархсан байна. Районы геологийн тогтоцод цэрдийн систем ба доод палеозойн бүлгийн тунамал чулуулгууд цаашилбал дээд палеозойн интрузив чулуулгууд оролцоно.

Геоморфологи. Төслийн талбай нь Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн (3) дэд мужид хамаарна. Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай өргөгдмөл гадарга (Mz-Q)-ын дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн давхаргат талд байршина.

Гадаргын ус. Говьд уур амьсгалаас шалтгаалж гадаргын ус түн ховор. Төслийн талбай нь Галба-Өөш, Долоодын сав газарт хамаарагдана. Энэ сав газарт 489 булаг, шанд, 30 нуур, цөөрөм байдаг.

Газрын доорх ус. Говьд гадаргын ус ховор учир ус хангамжид газар доорх ус ач холбогдолтой юм. Тухайн судалгааны талбай орчимд урьд өмнө газрын доорх усны хайгуул судалгаагаар тогтоогдсон Зээгийн хөтлийн газрын доорх усны орд болон Шанаган могойтын хэсэг дэх газрын доорх уснууд байна.

Хөрсөн бүрхэвч. Талбайн хэмжээнд заримдаг цөлийн цайвар бор хөрс тархана. 1 хэв шинж, 2 дэд хэв шинжийн хөрс (заримдаг цөлийн элсэнцэр цайвар бор хөрс, заримдаг цөлийн хөнгөн шавранцар бор хөрс) тархсаны төсөл хэрэгжих талбайн ихэнх хэсэгт заримдаг цөлийн элсэнцэр цайвар бор хөрс тархсан байна. Хөрсний өнгөн гадарга голдуу элсэн-элсэнцэр сайр чулуу багатай 40% хүрнэ. Үлдсэн талбайд тархсан заримдаг цөлийн хөнгөн шавранцар бор хөрсний өнгөн гадарга жижиг сайр чулуурхаг 50%, бутлаг бударганын төрлийн ургамлын бүрхэц 10 %.

Судалгааны талбайн хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, өнгөн үед бага, гүн рүүгээ дунд зэрэг карбонаттай, ялмаг агууламжаар маш бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнд фосфор болон калийн хангамжаар маш бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Ургамлан нөмрөг. Төслийн талбай нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө цөлийн хээрийн ургамалжилтай.

- Хазаар өвс- Орог тэсэгт бүлгэмдэл. Тусгагийн бүрхэц 33%, нийт 18 зүйлийн ургамал ургана. Зонхилогч ургамлын хувьд үетнээс өдлөг хялгана, зүүнгарын хазаар өвс, дэрс, монгол ерхөг алаг өвснөөс таана, хөмүүл, нарийн улалж, аммоний сэдэргэнэ, янгиц, цөөн наст ургамлаас булган сүүл, бага, хургалж, толгодын будраа, шүлхий шарилж, сөөглөг ургамлаас бор бударгана, алтлаг харгана ургах бөгөөд 100м², талбайд 52ш 5-40см диаметртэй ургана.
- Ахар навчит баглуур- Улаанбударганат бүлгэмдэл. Зүйлийн бүрэлдхүүн 19, ургамлын бүрхэц 27%, үүнээс сөөгний бүрхэц 15 %. Ургамлан нөмрөгийн өндөр 5-10см, улаан бударгана, шар бударганы буттай. Ургац 1м² талбайд 3.2 ц/га. Зонхилогч ургамлын хувьд үетнээс дэрвээн хазаар өвс, говийн хялгана, алаг өвснөөс толгодын бударгана, таана хөмүүл ургана. Талхагдал бага. Энд ургамлын нөөцийн төрөл зүйлийн ЭЭЗҮ-ний нэн ховор тархалттай ургамлын жагсаалтад орсон хулангийн ундаа 1-ээс бага арвитай ургасан.
- Баглуурт хармаг- шар бударгана, хармагт бүлгэмдэл. Тусгагийн бүрхэц 35-45%, 17 зүйлийн ургамал бүртгэгдсэн, ургац 4,8ц/га. Зонхилогч ургамлын хувьд үетнээс дэрс, алаг өвснөөс сибирь агь, хависгана заримдаг сөөгөнцөрөөс баглуур, хармаг, шар бударгана, улаан бударгана ургана. Ашигт ургамлын жагсаалтад элбэг тархалттай 3 зүйл ургамал ургана. Бэлчээрийн талхагдал дунд зэрэг

Түүх соёл, археологийн дурсгалт зүйлс: Түүхийн дурсгалт Археологийн олдворыг харьяа байгууллагын захиргаанд тайлагнаж байхыг соёлын өв үнэт зүйлсийг хамгаалах хуульд заасан байдаг. Тэдгээр түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд археологийн аль ч олдвор улсын өмч болдог. Археологийн ба соёлын өв үнэт дурсгалт зүйлс нь байгальдаа нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг. Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий шинжилгээний байгууллага тэдгээрийг бүртгэн авч нүүлгэн шилжүүлж болно.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслөөс үүсэх гол нөлөөллүүд

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт. Байгалийн төрөл зүйлүүдээс зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллийн зэрэг нь “бага”, харин агаар орчны бохирдол, газар доорх усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл бараг дундаас бага зэрэгтэй байсан бол геологийн тогтцын өөрчлөлтөд хөрсний элэгдэл, эвдрэл ба бохирдол, ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт зэрэг нөлөөлөл дунд зэрэг байхаар гарсан байна.

Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт. Нүүрс тээвэрлэх үйл ажиллагааны үед гарах тоос, тоосонцроос бохирдох бохирдол их, хөрсний бохирдол, агаар орчны дуу чимээний физик бохирдол, үндны усны чанар хэмжээнд “дунд” зэргээр нөлөөтэй үнэлэгдэж байна.

Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл. Байгалийн үзэсгэлэнт төрх, орчны ландшафтын хэлбэр өнгө төрх, тусгай хамгаалалтай газарт үзүүлэх нөлөөлөл байхгүй. Түүх соёлын дурсгалт зүйл, археологийн олдворт үзүүлэх нөлөөлөл байхгүй байна.

Бусад нөлөөлөл. Автозамын тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих болон байгалийн давагдашгүй хүчин зүйл /хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга/-ийн нөлөөллийн зэрэг “бага” байхаар байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Үндсэн зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. Тиймээс төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзээд холбогдох зардлыг төлөвлөнө. Энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх;
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй болох зэрэг болно.

Хамрах хүрээ

БОМТ нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт хэрэгжих “Гаалийн хяналтын талбайн” үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон нь байна. Уг төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий төлөвлөгөөнд БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээн дэх бүхий л асуудлыг хамрахад БОМТ нь дараах 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ),
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцөлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нүүрс тээвэрлэх, ачих буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх ажлын үед тоосжилт үүсэх	Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох (шороон замд 20-40 км/цаг-с хэтрүүлэхгүй), шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлэх	Нүүрс ачиж буулгах талбай	ш	100.0	3	300.0	2025	
2	Нүүрсний овоолго, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх - Усалгааны усыг зөвхөн хэрэгцээт газарт, илүүдэл асгаралтгүйгээр хийх. - Талбайн халцарсан хэсгийг нөхөх, тоос босгох эх үүсвэрийг арилгах. - Тоос дарагч бодис (эко, усанд уусдаг шийдэл) хэрэглэх. - Усалгаа хийх тусгай машин (усалгааны цистерн) ашиглах. - Замын өргөн, уртад тохируулан ус шүршигчийн даралт, тархалтыг тохируулах. - Замын гадаргууг жигд чийгшүүлэх.	Эзэмшил талбай болон төв зам хүртэлх зам талбай		1,000.0		Өглөө (06:00–09:00) болон орой (18:00–21:00) цагуудад услах нь ус ууршилтыг багасгаж, үр дүнтэй байдаг. Тоосжилтын эрчим, цаг агаарын нөхцлөөс хамаарч услах. Салхи багатай үед услах нь үр ашигтай.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль: Энэхүү хуульд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах талаар заасан байдаг. Усалгааны үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг хангах үүднээс энэ хуулийг мөрдөх шаардлагатай. Усны тухай хууль: Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх талаархи зохицуулалтыг тусгасан. Усалгааны ажлыг явуулахдаа усны нөөцийг үр ашигтай ашиглах, хэмнэх арга хэмжээг төлөвлөхдөө энэхүү хуулийг баримтлах хэрэгтэй.	
3		Нүүрс ачаад гарч байгаа машинуудыг 100 хувь бүтээлттэй байлгах арга хэмжээг авч ажиллах	Бүх ачилтын машин			-		Тээвэрлэлттэй өдөр бүр	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Агаарын чанарын бохирдол	Ашиглагдаж буй машин техникийг үзлэг оношилгоонд хамруулах	бүх тээврийн хэрэгсэл, машин механизм/		Үйл ажиллагааны зардалаар			Жил бүр	Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль, MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 4585 :2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
5	Хүний үйл ажиллагаагаар бий болгосон зохиомол ландшафт гадаргыг бий болгоно.	Төлөвлөгдсөнөөс өөр талбайд нүүрсний овоолго үүсгэхгүй байх, талбайг зохион байгуулалттай, ашиглах, илүү ашиглалт үүсгэхгүй байх	Нийт талбай		Төслийн төлөвлөлт, дотоод зардлаар гүйцэтгэх боломжтой			2025 он	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ” MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
6	Хөрс, газрын гадаргын бохирдол	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, Ил задгай энгийн болон аюултай хог хаягдал асгахгүй байх	Нийт талбай		Дотоод төлөвлөлтөөр			Сар бүр	
Сөрөг нөлөөг бууруулах нийт зардал, мян.төг						1,300.0			

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм.

Газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байх.

Хүснэгт 3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал ¹ , төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих 0.2 га талбайг зүлэгжүүлэх	Ойжуулалт ба зүлэгжүүлэлт хийх талбайн нөхцөлийг бүрдүүлэх Цаг уур, уур амьсгалын онцлогт тохирсон мод, сөөг (хайлаас, сухай, жигд, харгана,гүйлс) тарьж ургуулах Ерхөг: согоовор:Цаграс-1:1:2 харьцаатайгаар тарих	- 450 м тууш талбайд 50ш суулгац - 0.2 га талбайд	Ширхэг	50	11,250	562.5	2025 онд	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4 - Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
2	Мод бутны арчлалт хамгаалалт	Ургаагүй мод бутыг нөхөн тарих арчлалт хамгаалалт хийх	Төслийн талбай	удаа	50	-	-	-	
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг				562.5.0					

¹ <http://ecoline.tcgroup.mn/index.php/en/2013-04-30-23-44-01>

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих орчинд сум суурин газар олон жил үйл ажиллагаа явуулсан, тэмдэглэгдэж бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйл сумын төвийн тухайн орчинд байхгүй.

Төслийн үйл ажиллагааны явцад талбайн хөрсөнд өмнө нь судалгаагаар илэрч байгаагүй олдвор илэрч болдог. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Гал түймэр	Одоогийн байгаа гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, дутуу хэрэгслийг нэмэх, сэлбэх	Төслийн бүх байршилд	Дотоод төлөвлөлт				Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг
Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах, бүртгэл хөтлөх	Төслийн бүх байршилд					Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 5 дугаар бүлэг, Замын хөдөлгөөний дүрэм, Замын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг
Автомашины осол	Жолооч нарын, аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрдүүлэх, техникийн бүрэн байдлыг тогтмол шалгах хурдны хязгаар тогтоох	тээвэрлэлт					
	Нийт дүн		-				

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслөөс гарах хог хаягдлын төрлүүд ба хэмжээ: Төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа. Бид БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал		
Дахин боломжтой ашиглах	Цаас	9 ажилтан сард 0.4кг/хүн бичиг цаасны хаягдал
	Шил	Хүнсний баглаа боодлоос 9 хүн/хон*0.6 =5.4 кг
	Хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 9 хүн/хон*0.5=4.5 кг
	Резин	Техникийн ээлжийн тоогоор тооцно.
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: - Ундааны сав баглаанаас 9 хүн/хон* 0.3=2.7 кг - Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах металлыг тооцоолох боломжгүй байна
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	$9\text{хүн} \times 0.1\text{кг} \times 30\text{хоног} \times 12\text{сар} = 324\text{кг}$
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Нийт ажиллагсдын хэрэглээнээс $9\text{хүн} \times 0.15\text{кг} \times 30\text{хоног} \times 12\text{сар}$ тооцоход 486 кг
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн хүрээнд унд ахуйд ашиглах усны 90 хувь нь ахуйн бохир болж хаягдана.
Аюултай хог хаягдал		
Батарей аккумулятор	Хар тугалгатай батарей	Техникийн ээлжийн тоогоор гарна.
Хаягдал тос ба шингэн түлш	Түлшний тос, дизель	Техникийн ээлжийн тоогоор гарна.
Шингэн хадгалах танк, зөөврийн танк, торхны цэвэрлэгээний хаягдал	Тос агуулсан хаягдал	Тос агуулсан хаягдал нь: - Тос агуулсан арчих материалын хаягдал - Тос агуулсан хөрсний хуулдас
	Хаягдал шингэн катализатор	Тооцох боломжгүй. Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглэнэ.
Хөдөлгүүр, хайрцгийн болон тосолгооны тосны хаягдал	Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

Хог хаягдлын ангилал. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг дээр заасан байдлаар ангилах бөгөөд тэдгээрт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж төслийн талбайн орчинд хог хаягдлыг ангилах, ангилсан хог хаягдлыг төвөг багатайгаар цуглуулах тухай мэдээллийг үйлчлүүлэгч олон нийтэд мэдээлж сурталчлахын зэрэгцээ хогийн цэгүүдийг оновчтой байршуулж холбогдох тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийнэ.

Хүснэгт 5. Хог хаягдлыг зайлуулах

Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал	
цаас	Дахин боловсруулах боломжтой тул эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхийн тулд гэрээ хийнэ. Түр хадгалалтын цэгийг хуримтлагдах хэмжээ, тээвэрлэлтийн хугацаатайгаа уялдуулан төлөвлөсөн байна.
шил	
хуванцар,	
резин,	
металл, төмөр	Маш бага хэмжээтэй гарах бөгөөд хэт бохирдолтой, удаан хугацаагаар хадгалах боломжгүй хаягдал тул хамгийн цөөндөө 7 хоногт 2 удаа зайлуулна. Тиймээс эрх бүхий этгээдээр тогтоосон хугацаанд тээвэрлүүлэн зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлнэ.
Хүнсний хаягдал, (гал тогооны хаягдал)	
Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Бохирын цооногт хуримтлуулан эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулан зайлуулна.
ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдал	
Аюултай хог хаягдал	
Хар тугалгатай батарей	Аюултай хог хаягдлын зөвлөмжийг баримтална. Эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Ашигласан тос, масло	Аюултай хог хаягдлын хадгалалтын нөхцөл шаардлага хангасан цэгт хадгалж байгаад эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Хаягдал шингэн катализатор	Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглүүлнэ.
Машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

Хог хаягдал цуглуулах саванд тавигдах ерөнхий шаардлага

5.1 Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах зөөврийн сав нь дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- 5.1.1. Хогийн сав нь бат бөх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, зэврэлтээс хамгаалагдсан байх
- 5.1.2. Хогийн савны хог цуглуулах хэсгүүд нь дахивар хог хаях зориулалтыг заасан стандарт мэдээлэх тэмдэг, өнгөтэй байх
- 5.1.3. Хогийн сав нь хог хаягдлыг ангилах, цуглуулах, ачих, тээвэрлэх технологид нийцсэн байх
- 5.1.4. Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн таг эсхүл саравчтай байх
- 5.1.5. Түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байх
- 5.1.6. хогийн савны металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалж энэхүү стандартад заасан өнгөөр, стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байх
- 5.1.7 энгийн болон дахин боловсруулах хог хаягдлын савыг техникийн хяналтын төвүүдэд (бойлерын өрөө эсхүл агааржуулалтын систем) байрлуулж болохгүй. Аливаа хий, ус эсхүл гүйдлийн тоолуур эсхүл бусад мэдрэмтгий хэрэгслийн гэмтлээс бүрэн хамгаалсан байх
- 5.1.8. органик хог хаягдлын хувьд хангалттай агааржуулалтыг хийж байх шаардлагатай, агааржуулалт нь цахилгаан эсхүл байгалийн хэлбэрээр байж болно. Агаар солилцооны харьцаа нь хамгийн багадаа 0.8 м³/ц байна.

- 5.1.9. Хогийн сав нь нарны шууд тусгал тусахаас сэргийлсэн саравч эсхүл сүүдэр газар байршсан байна.

5.2. Энгийн хог хаягдал болох ахуйн хог хаягдал, органик хог хаягдал, цаас, шил, хуванцар, лааз зэрэг дахивар хог хаягдлыг тухайн төрлийн заасан савнуудад цуглуулж тодорхой хугацаанд хадгална.

5.3. Органик хог хаягдал нь гадаргууг хуурах, зэв үүсэх нөхцөл бүрдүүлдэг тул цайраар бүрсэн ган болон төмөр саванд хадгалж болохгүй. Цуглуулах савны дүүргэлт доорх байдлаар байвал тохиромжтой. Үүнд

5.3.1. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар $0,4\text{кг}/\text{дм}^3$ х нэрлэсэн хэмжээ (жишээ нь: 240 литр х 96кг)

5.3.2. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар $0,4\text{кг}/\text{дм}^3$ х нэрлэсэн хэмжээ, 1750 кг хүртэл

5.3.3. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар $0,4\text{кг}/\text{дм}^3$ х нэрлэсэн хэмжээ, 2500 кг хүртэл



Зураг 6. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав/жишээ/²

Хүснэгт 6. Аж ахуй нэгж байгууллага байршуулах хогны савны шийдэл

Хэмжээ	Шийдэл	
Урт-3м Өндөр 1.5м Өргөн 1.5м	• Хүний биеийн өндөрт тохирсон • Савны амсрыг зөвхөн дахивар хийхээр тооцож хийсэн • Ангилсан хаягдлыг ачихад хялбараар шийдэж дахивар бүрээр салж ачилт хийгдэнэ. • Хаягжилтыг цоолтуураар шийдсэн • Шил ангилах хэсэг нь унаж хагарахаас сэргийлсэн, том жижиг хэмжээтэй	• Ус орохоос хамгаалж газраас хөндий • Хоёр талаасаа дахивраа хийх шийдэлтэй п • Нараар цэнэглэгдэж хүн ойртохоор мэдэрч асдаг гэрэлтэй • Савнуудыг холбосон салахгүй байх оньсон түгжээтэй • Ангилан ялгах өнгийг шийдсэн.

² [Хотын стандарт | Хотын стандарт, хяналтын газар \(ub.gov.mn\)](#)



Зураг 7. Нүхэн жорлон ариутгах³

Халдваргүйжүүлэлтэнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан хлорлог бодисыг хэрэглэнэ.

Хлорлог бодисыг ашиглан халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх:

Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэхийн өмнө хлорын идэвхийг тодорхойлно. Иргэд өөрсдөө халдваргүйтгэл хийх бодисоо худалдан авахдаа идэвхтэй хлорын хэмжээг тодорхойлсон шинжилгээний дүнг мэдэж авах нь чухал.

Дараах томъёог ашиглан уусмал бэлтгэхэд шаардлагатай бодисын хэмжээг тооцон гаргана

Бэлтгэх уусмалын% / хлорын идэвх% x 1000 = 1л ус тутамд хийх бодисын хэмжээ /гр/

Жишээ: 40%-ийн идэвхтэй кальцийн гипохлорит 0.5%-ийн 1 л уусмал бэлтгэхэд хэчнээн хэмжээний бодис авахыг тооцож үзье.

$t = 0.5\% / 40\% \times 1000 = 12.5$ грамм

12.5 грамм бодис жинлэн авч 1 литр усанд уусган хэрэглэнэ.

АНХААР: Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх усны температур 30-40 градус байх нь тохиромжтой.

Хуурай бодисоос халдваргүйжүүлэх уусмал бэлтгэсэн тохиолдолд уусаагүй хэсгийг тунгаах зорилгоор 30 минут байлгаж хэрэглэнэ

Хэрэглэх арга: Халдваргүйжүүлэлтийн уусмалыг 1 м³ талбайд 2 литр уусмал орохоор тооцож, нүхэн жорлон, бохирын цооногийн эзлэхүүнд тохируулан уусмалаа бэлтгэнэ.

Халдваргүйжүүлэлт хийсний дараа 1-2 цаг нүхэн жорлонгийн хаалгыг хааж, бохирын цооногийг таглана.

³ Нүхэн жорлонд халдваргүйжүүлэлт хийх зөвлөмж (inspection.gov.mn)

Гэр хорооллын нүхэн жорлон, бохирын цооногт дулааны улиралд сард нэг удаа, хүйтний улиралд гурван сард нэг удаа халдваргүйжүүлэлт хийнэ.

Хана, тааз, гишгүүрийг шүршиж халдваргүйжүүлнэ.

Аюулгүй ажиллагаа: Халдваргүйжүүлэлтийн бодисыг найруулах хэрэглэхийн өмнө зааврыг сайтар унших, зааврын дагуу найруулна.

Уусмал бэлтгэхдээ хамгаалах өмсгөл, бээлий маск, нүдний шил хэрэглэнэ.

Санамсаргүй тохиолдлоор хуурай бодис, бургиж нүд рүү орсон бол үрсгал, бүлээн усаар сайтар угаах, амьсгалын замаар орсон бол цэвэр агаарт гаргах шаардлагатай.

- Найруулсан уусмалыг тухайн өдөртөө хэрэглэнэ.
- Бодисыг хүүхдээс хол байлгана.
- Хуурайгаар хэрэглэхийг хориглоно.

Гаалийн хяналтын талбайд байгаа ашиглалтаас гарсан нүхэн жорлонг “Нүхэн жорлон, угаадасны нүх” MNS 5924:2015 стандартын дагуу доорх шаардлагын дагуу ариутган булах шаардлагатай.

- ✓ Буулгах шаардлага. Дахин ашиглах боломжгүй жорлон, угаадасны нүхний бохирдсон хөрсийг зайлуулж халдваргүйжүүлэлт хийн эрүүл хөрсөөр дүүргэж ариутгана.
- ✓ Нэвчилттэй жорлон, угаадасны нүхний эзлэхүүний 90 хувь нь ялгадас, хөлдүүсээр дүүрэх үед жорлонгийн бүхээгийг зайлуулан нүхийг 30см-ээс багагүй зузаан шороогоор булна. Ялгадас доош шингэж хөрс суулт өгөх бүрд шороогоор нэмж булна.
- ✓ Жорлон, угаадасны нүхэн жорлон доторх ялгадас, угаадсыг соруулж халдваргүйжүүлэлт хийсний дараа эрүүл хөрсөөр дүүргэж булна. Ялгадас, угаадсыг зөвшөөрөгдсөн цэгт зохих журмын дагуу зөөж зайлуулна.
- ✓ Жорлон, угаадасны нүхэн доторх ялгадас, угаадсыг соруулж халдваргүйжүүлэлт хийсний дараа эрүүл хөрсөөр дүүргэж булна. Ялгадас, угаадсыг зөвшөөрөгдсөн цэгт зохих журмын дагуу зөөж зайлуулна.
- ✓ Жорлон, угаадасны нүх байсан суурин дээр мод, зүлэг тарьж хөрсийг нөхөн сэргээнэ.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулах	Талбайн нийт ахуйн хаягдал	ш	1,000.0	1	1,000.0	2025	UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт “Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” (БОАЖС-ын 2018 оны А/443 дугаар тушаал). “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам” “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924 : 2015
		Эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ сунгуулах, гэрээний дагуу ачуулах		удаа	40,000	12	480.0		
2.	Ариутгал, халдваргүй-жүүлэлт хийх, цэвэрлэгээ	Хогийн цэг, нүхэн жорлон, бохирын цооног болон ажилчдын байр зэргийг ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Хогийн цэг, нүхэн жорлон, бохирын цооног	Удаа	-	Жилд 1 удаа	100.0		
Нийт			1,580.0						

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР ⁴								
1.	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM _{2.5} , PM ₁₀) шинжилгээ хийлгэж байх	- Гаалийн хяналтын талбайн салхины зонхилох чиглэлийн дагууд 2 цэг	Жилд 1 удаа	2	60,000.0+50,000.0 техникч томилолт	170.0	Нэг удаагийн хэмжилтээр 2 ажиглалтыг нэг мөр хийнэ.	- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 17.2.5.12 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ - MNS 5919 : 2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын баус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
2. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ ⁵								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	- Ашиглалтад өртөөгүй талбай/фон цэг/	Жилд 1 удаа	1	25.0	25.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх	MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”,

⁴ Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн агаарын шинжилгээний үнээр тооцов.

⁵ “Нарт ШУУН КОНСОЛТИНГ” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторийн үнээр тооцов.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
2	Хөрсний бохирдлын шинжилгээ /6 элемент/	- Хогийн цэгийн орчим - Авто зогсоол		2	25.0	50.0	нь зүйтэй.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал.хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
3	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	- Хогийн цэгийн орчим - Нүхэн жорлонгийн ойролцоо		2	25.0	50.0		
УСНЫ ЧАНАР								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	Хэрэглээний усаа зөөврөөр хангадаг худаг	2025 онд 1 удаа	1	49.0	49.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй.	MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Усны бохирдлын хяналт хийх			1	78.0	78.0		
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх жилийн гүйцэтгэлийн зардал, мян.төг								422.0

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	тайлбар
			2025 он					
			I	II	III	IV		
1.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх;	“Баялаг хатанбулаг хөгжил” ХХК - аас зохицуулах		+	+		Удирдах албан тушаалтан + асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Шаардлагатай тохиолдолд удирдах дээд байгууллагаас асуудлыг тавьж шийдвэрлүүлэх хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.
2.	Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох			+	+			
3	Дотоодод боловсруулсан дүрэм журмуудыг мөрдүүлэх, хяналт тавих	“Баялаг хатанбулаг хөгжил” ХХК - аас зохицуулах	+				Гаалийн хяналтын талбай хариуцсан эрхлэгч	
	Нийт	Дотоод төлөвлөлтөөр						

АРВАН ХОЁР. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
2	Төслийн харьяаллын багийн ИНХ, төслийн талбай орчмын оршин суугчид	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга эсвэл цахим тайлан	БОМТ-ний биелэлтийн тайлан	2025 оны 11 сарын 1-ний дотор	“Баялаг хатанбулаг хөгжил” ХХК -ийн асуудал хариуцсан мэргэжилтэн	200.0	-
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг							200.0

БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДАЛ

Төслийн үйл ажиллагаанд БОМТ-г хэрэгжүүлэхэд 2025 онд нийт 4,064,500 төгрөгийн зардлыг тусгалаа.

Хүснэгт 11. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал

№	БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бүүрүүлэх арга хэмжээ	1,300.0
2	Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	562.5
3	Түүх соёлын өвийг хамгаалах	-
4	Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	-
5	Хог хаягдлын менежментийг зохион байгуулах	1,580.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	422.0
7	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	-
8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	200.0
Нийт зардал		4,064.5

Хавсралтууд

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000207985

2021.06.10
/ Бүртгэгсэн он, сар, өдөр /

0611008298
/ Хувийн хэргийн дугаар /

3323358
/ Регистрийн дугаар /

Баялаг хатанбулаг хөгжил
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

Дүрэм
/ Үүссэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

2021.06.07
/ он, сар, өдөр /

49230
/ Код /

Автомашинаар ачаа тээвэрлэх
Уул уурхайн чиглэлээр зөөлөгөө өгөх
/ Үйл ажиллагааны чиглэл /

72100

Хугацаагүй
/ хугацаа /

1
/ гишүүдийн тоо /

4.00
/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Дорноговь, Хатанбулаг, 5-р баг, Аман-Ус, эргэл, 15-7, Утас1: 99087158, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭС
/ Бүртгэгсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ
ТЭМДЭГ
28/1-32
/ Гэрчилгээний үсэг /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл			
Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Давшээвэг овоотой Нацагдорж-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.06.10	Ж.Болортуяа
2	Дэвдасамбуу овоотой Одонтүяа-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2022.06.28	Ж.Болортуяа
3	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.11.03	Ж.Болортуяа
4	Эцсийн өмчлөгч 1 нэмэгдэж 1 хасагдаж нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.11.03	Ж.Болортуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бод хуулийн үе



* 0 0 0 2 0 7 9 8 5 *

2. Газрын гэрчилгээ


МОНГОЛ УЛС
АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭ
Дугаар: 0000003455

Баялаг Хатанбулаг хөгжил	3323358
(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)	(регистрийн дугаар)
Сумын Засаг даргын захирамж	20 21 оны 10 сарын 18 өдрийн А/142 тоот
(шийдвэр гаргагч)	
шийдвэрийг үндэслэн	Дорноговь Хатанбулаг 3-р баг
(аймаг, нийслэл)	(сум, дүүрэг) (баг, хороо)
	0 хаягт
(гудамжны нэр)	(хашааны дугаар)
байрлах, нэгж талбарын	4408006329 дугаар бүхий 50000 м.кв газрыг
Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	зориулалтаар
10 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн	Э-0710000116


дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.



Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

Хэвлэсэн огноо: 2021-10-18

3. Газрын кадастр



4. Газрын захирамж


ДОРНОГОВЬ АЙМАГ
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 18 өдөр Дугаар А/142 Дорноговь аймаг, Хатанбулаг сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 3-р багийн нутаг дэвсгэр Ханги хилийн боомтын ойролцоо байрлах Ачилт буулгалтын талбай зориулалтаар олгосон 50000 м' хэмжээтэй газрын эзэмшигч (ЕМ75010270) регистрийн дугаартай, Ринчинновын Мөнхбаяр-ын хүсэлтээр (3323358) регистрийн дугаартай, 0611008298 улсын бүртгэлийн дугаартай “Баялаг хатанбулаг хөгжил ХХК”-д 10 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн А/93 дугаар захирамж, 000021252 дугаарт газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Газар эзэмших иргэнтэй гэрээ байгуулж, газрыг зориулалтаар нь эзэмшиж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Одчимэг)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА  С.ЭРДЭНЭБОЛД

• 442210372

ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (мөнгө 2)
 № 0615124
 ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД
 ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

Эрх бүхий албан тушаалтны харьяалах байдлыг харгалзан
 нэр, пост, зэрэгт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн үзэмж хэрэгтэй
 асуудлыг шалгаад ОДСОН нь
 Холбогдогч харьяалах улс, хуулийн этгээдийн нэр, хүний овог, нэр, регистр/паспортын дугаар, аймаг, албан тушаал, нөхөн
 болох нь /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн
 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна.
 Иймд холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 2.4
 зүйлийн -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйл
 заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн
 тусгай ангийн /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл
 оногдуулсугай.

2. Оногдуулсан шийтгэлийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, хохирол, нөхөн
 төлбөрийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг
 /улсын төсөвт/ Төрийн сангийн тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн
 дотор бэлнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн /үйт ажиллагаа, эрх/ аль болохыг
 зурах/-ыг хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох/ аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногдуулсугай.

4. Төргүүлийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан
 төгрөгийн төргүүлийн шийтгэлийг хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор,
 хувийг хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.

5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:
 А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/
 Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, гэврийн хэрэгсэл, уналга/, /аль нь болохыг доогуур зурах/
 В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/
 /аль нь болохыг доогуур зурах/
 /нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-г Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон
 Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгсэлээс
 хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу
 шийдвэрлэсүгэй.

6. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2
 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар -ны өдрийн дотор үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах,
 эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төгрөгийн зардлыг гаргуулсугай.

7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүтгээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар
 албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах
 шүүхэд хүсэлт гаргана.

8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах
 эрхтэй болохыг дурдсугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:
 Эрх бүхий албан тушаалтан
 ТАНИЛЦСАН:
 Холбогдогч

БАЙТАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
 УЛСЫН
 БАЙЦААГЧ
 0741-01899
 (нэр)
 (хуви) (үсэг)
 (нэр)

6. БОМТ төлөвлөгөөгүй ажилласан жилийн шийтгэлийн төлбөр төлсөн баримт

Банк хооронд

Гүйлгээ амжилттай хийгдлээ.



Гүйлгээний огноо
2025-03-20 17:28:41



Журнал дугаар
921091978832



Шилжүүлэх данс
300001865404



Банк
Төрийн сан



Дансны дугаар
100060000982



Хүлээн авагчийн нэр
До.МХГазар – орлого



Дүн
600,000.00 MNT



Гүйлгээний утга
БАЯЛАГ ХАТАНБУЛАГ ХӨГЖИЛ ХХК



Гүйлгээний зориулалт
Бусад төлбөр

Ok

7. Энгийн хог хаягдлын гэрээ

БАТЛАВ
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА. С.ЭРДЭНЭБОЛД

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАТАЙ
БАЙГУУЛАХ ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2023 оны сарын ... өдөр Амна ус

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.8, 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 01/06 дугаар тогтоол зэрэг нь энэхүү гэрээний үндэслэл болно.

Энэхүү гэрээг нэг талаас Хатанбулаг сумаас Засаг даргын Тамгын газрыг төлөөлж, Байгаль орчны бодлогын мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Жаргалсайханы Шинэтуяа нөгөө талаас Бадсан Ховган Буяал номин ХХК төлөөлж, МОНЧИР ажилтай Ч.МОНЧИР нар харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Гэрээний зорилго

2.1. Хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, орчны бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинг бий болгох, сумын төсвийн орлогыг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Засаг даргын Тамгын газрын эрх, үүрэг

3.1. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих
3.2. Аж ахуй нэгж байгууллагын хог хаягдал хаях түр цэгийг тогтоож мөрдүүлэх
3.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн барагдуулалтад хяналт тавих
3.4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал гаргаж буй Аж ахуйн нэгж, байгууллагуудад гэрээний хэрэгжилттэй холбоотой үүрэг чиглэл өгч шийдвэрлүүлэх

Дөрөв. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

4.1. Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх
4.2. Шаардлага хангасан зориулалтын хогийн цэгтэй байх
4.3. Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах
4.4. Гаалийн хяналтын талбайн орчинд хог хаягдал хаях түр цэгийг тогтоолгож, тохижуулсан байх
4.5. Орчныхоо газрын хог хаягдлыг цэвэрлэх, хогийг салхинд хийсгэхгүй байх

4.6.Үүсгэсэн хог хаягдал болон аюултай хог хаягдлын мэдээллийг нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлж аюулгүй байдлыг хангах

4.7.Хог хаягдлыг ялган ангилж, шатааж, булшлах

4.8.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Төрийн сан банкинд нэхэмжлэлийн дугаараар бүрэн төлөх

4.9.Кэмпийн талбай дотор хогийн савнууд байршуулах, хог хаягдлын цэгт харагдахаар хаяг самбар байршуулах.

4.10.Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн байгууллагуудад мэдэгдэх.

Тав. Төлбөр тооцоо

5.1.Хог хаягдал гаргах эх үүсвэр Көмп

5.2.Хог хаягдал гаргасны жилийн төлбөр (600 мянга)

Зургаа. Аж ахуй нэгжүүдэд хориглох зүйл

6.1.Хог хаягдлыг үерийн далан сувагт хаяхыг хориглоно.

6.2.Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно.

6.3.Хог хаягдлыг тогтоосон цэгээс бусад газарт хаяхыг хориглоно.

Долоо. Хариуцлага

7.1.Гэрээний заалтуудыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон Хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

Найм. Бусад

8.1. Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан тохиролцоно.

8.2.Хог хаягдал гаргасны төлбөр өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

8.3.Гэрээг 2023 оны 1 сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулав.

Гэрээ байгуулсан:

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН
МЭРГЭЖИЛТНИЙ ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.ШИНЭТУЯА

Утас 86586066

Баялаг Хатанбулаг ХХК-НЫ
Хөгжил
У.Монхтүвшин

Байгууллагын регистр 5525558
Утас 88862555